БАТЛАВ.
БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Т.НЯМ-ОЧИР

**"ХҮҮХДИЙГ БОЛЗОШГҮЙ ОСОЛ, ГЭМТЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОЛОН МАНСУУРУУЛАХ БОДИСЫН ХОР НӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ЭЦЭГ ЭХ, ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООТОЙ АЮУЛГҮЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЦОГЦ НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ" АЖЛЫН ДААЛГАВАР**

| | |
|---|---|
| **Үндэслэл** | Нэгдсэн Үндэстний Байгууллагын "Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба" (UNODC)-аас "Гэр бүлд болон сургуульд суурилсан урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхийг зөвлөмжилсөн.<br>Монгол Улсын хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой 1064 гэмт хэрэг, 1300 яллагдагч цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байна. Насны хувьд авч үзвэл 53.9 хувийг 18-25 насны залуучууд, 32.7 хувийг 26-35 насныхан эзэлж байна. |
| **Ажлын зорилго** | Хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийг үл хайхрах, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж эрсдэлт нөхцөлд оруулахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг бууруулах, сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодисын хор нөлөө, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх. |
| **Хамрах хүрээ** | Хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, олон нийт |
| **Гүйцэтгэгч байгууллагын хийж гүйцэтгэх ажлын хүрээ** | Хүүхдийн аюулгүй байдал, осол гэмтэл, сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодисын хор нөлөөний эсрэг эцэг эх, олон нийтийн оролцоотой аюулгүй орчныг бүрдүүлэх чиглэлээр цогц нөлөөллийн ажлыг зохион байгуулах |
| **Гүйцэтгэгч байгууллагын хийж гүйцэтгэх ажлын агуулга** | Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд хандсан контент:<br>• 5 төрлийн зурагт хуудас<br>• 5 төрлийн нөлөөллийн видео шторк<br>• 2 төрлийн нийтлэл<br>• 2 төрлийн ярилцлага видео |
| **Тавигдах шаардлага** | • Дээрх нөлөөллийн ажлуудын агуулга нь хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийг үл хайхрах, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж эрсдэлт нөхцөлд оруулахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийг гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг бууруулах, сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодисын хор нөлөө, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлд бүрэн нийцсэн байх<br>• Видео шторк дуу, дүрсний нягтрал сайтай байх<br>• Нийтлэл нь нөхцөл байдлын судалгаанд тулгуурлан бичигдсэн байх |

| | |
|---|---|
| | • Өмнө нь олон нийтэд түгээгдээгүй дахин давтагдашгүй бүтээл байх |
| **Хүлээгдэж буй үр дүн** | • Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн хүүхдийн өмнө хүлээх хариуцлага дээшилж, хүүхдийг үл хайхрах, хүүхдийн эрх зөрчигдөх, эсхүл эрсдэлт нөхцөлд байдлын талаарх мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна.<br>• Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтээр дамжуулан хүүхэд архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эмийн бодисын төрлийн гэмт хэрэг, зөрчилд холбогдох болон хорт зуршилд уруу татагдах эрсдэлийг бууруулах. |
| **Хугацаа** | 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл |
| **Төсвийн нийт санхүүжилт** | 65,000,000 (жаран таван сая) төгрөг |
| **Байршил** | Улаанбаатар хот, Монгол Улс |

---o0o---